

3

АМЬДРАЛЫН ЧАНАРТ НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ, МОНГОЛ УЛСЫН АМЬДРАЛЫН ЧАНАР

Б.Галбадрах

Оршил

Амьдралын чанар хэмээх ойлголтыг судалж түүний ач холбогдол, давуу болон сул тал, шийдвэрлэх асуудлыг нээж илрүүлэх нь энэхүү ажлын нэг зорилт юм. Амьдралын чанар нь нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны нөхцөл байдал зэрэг хүний хөгжил болон нийгмийн хөгжлийн асуудлуудыг тодорхойлогч үзүүлэлт юм. Иймээс улс орны нийгэм, эдийн засгийн дундаж үзүүлэлтүүдээс илүүтэйгээр амьдралын чанар нь тухайн улсын хөгжлийн түвшинг илэрхийлж харуулдаг.

Эдийн засгийн өсөлт нь тухайн улсын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өсөлтөөр тодорхойлогддог. Харин амьдралын чанар нь тухайн улсын амьдралын өртөг, эдийн засаг, хүрээлэн буй орчин, эрх чөлөө, ардчилал, эрүүл мэнд, дэд бүтэц, эрсдэл болон аюулгүй байдал зэрэг үзүүлэлтээр хэмжигддэг. Өөрөөр хэлбэл, амьдралын чанар нь хүний амьдрах нөхцөл байдлыг тодорхойлдог. Иймээс эдийн засгийн өсөлтөөс илүүтэйгээр амьдралын чанарын асуудлыг судлах нь бодлого боловсруулах түвшинд чухал ач холбогдолтой юм.

Амьдралын чанарт нөлөөлөх нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүдийн нөлөөг тодорхойлох нь уг ажлын гол шийдвэрлэх асуудал юм. Үүнийг шилжилтийн эдийн засагтай орнуудын амьдралын чанарын индекс, эдийн засгийн өсөлт, ажилгүйдлийн түвшин, инфляцийн түвшин, нэг хүнд ноогдох ДНБ, хүний хөгжлийн индекс болон эдийн засгийн эрх чөлөө гэх мэт хэмжигдэхүүнүүдийг ашиглан тодорхойлох болно. Үүнд 2005-аас 2008 он хүртэлх шилжилтийн эдийн засагтай орнуудын панел тоон өгөгдлийг үүсгэн эконометрикийн аргачлалыг ашиглан эмпирик судалгаа хийсэн.

Амьдралын чанар хэмээх ойлголтыг анх 1997 онд Ontario-ийн нийгмийн хөгжлийн байгууллага тодорхойлж байсан бөгөөд 2005 оноос эхлэн улс орнуудын амьдралын чанарын индексийг "Internationalliving" олон улсын

байгууллага тооцож эхэлсэн. Манай улсын хувьд амьдралын чанартай холбоотой ажил урьд нь хийгдэж байгаагүй. Харин гадаадад хийгдсэн олон ажлууд байдаг. Эдгээр ажлуудыг судалж, судалгааны арга, үр дүн болон онцлогуудыг нэгдүгээр бүлгийн төгсгөлд орууллаа. Миний хийсэн судалгааны ажил нь шилжилтийн орнуудыг хамруулан, панел өгөгдөл ашиглан эконометрик аргачлалаар амьдралын чанарт нөлөөлөх нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн нөлөөг судалснаараа шинэлэг болсон гэж үзэж байна. Бүлэг 1. Амьдралын чанар түүнд нөлөөлөгч хүчин зүйлс

1.1 Амьдралын чанар түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн онол

1.1.1 Амьдралын чанар

Амьдралын чанарыг зөвхөн эрүүл мэндээр тайлбарлах хандлага байдаг. Эрүүл мэндийн амьдралын чанарын шинжилгээ нь хүний амьдралд нөлөөлөх өвчин эмгэгийн нөлөөлөл болон эмчилгээний нөлөө зэргийг авч үздэг. Энэхүү шинжилгээнд нийгмийн байдал, эрүүл мэндийн бодит нөлөөллүүд, хүний өдөр тутмын амьдрал дахь өвчлөл, эмчлүүлэгчдийн цаашид өвчлөх магадлал зэргийг авч үздэг. Амьдралын чанарын суурь ойлголт нь эрүүл мэнд бөгөөд Канадын эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан "Хүний эрүүл мэндийн хөтөлбөр"-т тааснаар эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлсийг ашиглан тайлбарладаг. Үүнд:

- Орлого болон нийгмийн байдал (статус)
- Нийгмийн халамжийн сүлжээ
- Ажил эрхлэлт ба хөдөлмөр хамгаалал
- Нийгмийн орчин
- Хүрээлэн буй орчин
- Хүүхдийн эрүүл мэндийн асуудал

Дээрх хүчин зүйлс нь хүний эрүүл мэндэд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Амьдралын чанарыг эрүүл мэндийн ном зохиолууд дээр олон төрлийн хандлага, арга зүй болон бүрэлдэхүүн хэсгүүдийнх нь үүднээс авч тайлбарласан байдаг. Түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд олон нийтийн эрүүл мэндийн байдал, хөдөлмөрийн бүтээмж, сайн сайхан байдал, амьдралд сэтгэл хангалуун байх, аз жаргалтай байдал, сэтгэлгээний түвшин, өвчлөл, халдварт өвчин, ядаргаа, нийгмийн идэвх, санхүүгийн байдал болон ажиллах нөхцөл байдал гэх мэт хүчин зүйлс ордог.

1997 оноос эхлэн амьдралын чанар хэмээх ойлголтыг илүү өргөн хүрээнд авч үзэх болсон.


Амьдралын чанарын тодорхойлолтуудаас авч үзье.

Soren Ventegodt "амьдралын чанар гэсэн ойлголт нь сайхан амьдрал гэсэн утгыг харуулна. Сайхан амьдрал гэдэг нь өндөр чанартай амьдрал гэсэнтэй ижил утгатай юм"¹⁴ гэж тодорхойлжээ. Харин Malcolm Shookner "нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хүчин зүйлсийн хоорондын харилцан үйлчлэл нь нийгмийн

¹⁴ Soren Ventegodt, Joav Merrick, Niels Jorgen Anderse, 1997, page 1

болон хүний хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг амьдралын чанар харуулна”¹⁵ гэжээ. Зураг 1.

Зураг 1. Амьдралын чанар



Эх үүсвэр: (Malcolm , 1997, page 5)

1.1.2 Амьдралын чанарын индекс

Амьдралын чанарын индекс нь нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин болон амьдралын чанарын талыг илэрхийлдэг эдийн засгийн хэмжигдэхүүнүүдийг ашиглан нийгмийн хөгжлийн түвшинг илэрхийлэх зорилготой юм.¹⁶ Амьдралын чанарын индекс нь дээрх хэмжигдэхүүнүүдийн хүмүүст үзүүлэх нөлөө болон амьдралын чанарыг хэрхэн сайжруулах тухай маргаантай асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

International living олон улсын байгууллага амьдралын чанарын индексийг доорхи үзүүлэлтүүдийг ашиглан тооцдог.¹⁷

- Амьдралын ортог (15%) : Энэ нь тус улсад амьдрахад хэр зэрэг зардал гаргахыг харуулдаг.
- Соёл урлаг, чөлөөт цаг (10%) : Үүнд бичиг үсэг тайлагдалтын түвшин, 1000 хүнд ноогдох сонин сэтгүүлийн тоо, анхдагч болон хоёрдогч сургуульд элсэгчдийн харьцаа, нэг музейд ноогдох хүн амын тоо зэрэг соёлын хүчин зүйлсийг тооцдог. Мөн сургуулиас өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо болон бүх шатны сургуульд хамрагдсан суралцагчдын тоог авч үздэг.
- Эдийн засаг (15%) : хүүгийн түвшин, дотоодын нийт бүтээгдэхүүн, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн түвшин, нэг хүнд ноогдох ДНБ, инфляцийн түвшин, ажил эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин, жуулчдын тоо
- Хүрээлэн буй орчин (10%) : нэг километр квадратад ноогдох хүн амын нягтрал, хүн амын өсөлтийн түвшин, хамгаалалтанд авсан нийт газрын хувь зэргийг тооцно.
- Эрх чөлөө, ардчилал (10%) : иргэний улс төрийн эрх, ардчилал

¹⁵ Malcolm Shookner, 1997, page 5

¹⁶ Malcolm Shookner, 1997, page 6

¹⁷ internationalliving, www.qualityoflife2008.com

- Эрүүл мэнд (10%) : дундаж наслалт, өдөрт шаардлагатай илчлэгийг хэрэглэх түвшин, нэг эмчид ноогдох хүн, 1000 хүнд ноогдох эмнэлгийн орны тоо, 10000 хүн амд ногдох халдварт өвчин, баталгаатай цэвэр усаар хангагдсан хүн амын хувь, нялхсын эндэгдлийн түвшин, амьдрах магадлал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, нийгмийн эрүүл мэндийн зардлын улс орны нийт дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь зэргийг тооцоолно.
- Дэд бүтэц (10%) : үүнийг хэмжихдээ тухайн орны төмөр замын урт, усан зам, хүн ам болон газар нутгийн тэнцвэрт байдал зэргийг тооцоолдог. Мөн нисэх онгоцны буудал, хөдөлгүүрт ачаа тээвэрлэгч, телефон, интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн тоо болон 1000 хүнд ноогдох суурин болон үүрэн телефон зэргийг тооцоолдог.
- Эрсдэл болон аюулгүй байдал (10%) : аюул ослын тэтгэмж, хүндээр өвчлөх болон аюултай нөхцөл байдалд амьдарч байгаа хүмүүс болон бүртгэгдсэн гэмт хэргийн тоо
- Цаг агаар (10%) : жилийн дундаж хур тунадас болон дундаж температур, болон байгалийн гамшгийн эрсдэл зэргийг тооцоолно.

Бүлэг 2. Монгол улсын амьдралын чанар

Манай улсад амьдралын чанартай холбоотой хийгдсэн ажил маш ховор байдаг. 1993 онд Сангийн яам Монгол улсын амьдралын чанарын өргөтгөсөн бодит индексийг тооцоолсон байна. Уг индекс нь дараах үзүүлэлтүүдийн арифметикийн дундаж юм. (Дундаж наслалт, Бичиг үсэг тайлагдалтын түвшин, Бага болон дунд боловсролын шатны сургуульд хамрагдсан байдал, Жилд нэг хүнд ноогдох калорийн хэрэглээ)

Үзүүлэлт бүрийг 0-100 хооронд оноогоор хэмждэг бөгөөд Монгол улсын хувьд амьдралын чанарын өргөтгөсөн бодит индекс нь 58,6 гарсан байна. Энэхүү тооцоог ямар эх сурвалж, хэдэн оны тоо мэдээ ашиглаж гаргасан нь тодорхойгүй байна.

Манай орны амьдралын чанарын индексийг “Internationalliving” олон улсын байгууллага сүүлийн дөрвөн жил тооцоолсон байна. (Хүснэгт 1)


Хүснэгт 1. Монгол улсын амьдралын чанарын индекс 2005-2008

Үзүүлэлтүүд	2005	2006	2007	2008
Амьдралын өртөг	70	78	86	63
Соёл урлаг, чөлөөт цаг	52	65	67	63
Эдийн засаг	32	43	39	35
Хүрээлэн буй орчин	70	72	77	70
Эрх чөлөө, ардчилал	83	83	83	83
Эрүүл мэнд	42	55	58	58
Дэд бүтэц	40	41	34	50
Эрсдэл болон аюулгүй байдал	50	50	64	64
Цаг агаар	14	1	7	14
Амьдралын чанарын индекс	50	55	57	55

Эх үүсвэр: <http://www.internationalliving.com>


Манай улсын хувьд амьдралын өртөг гэсэн хэмжүүрээр хамгийн өндөр оноог авсан байна. Энэ нь манай улсад харьцангуй бага зардалтайгаар амьдардаг болохыг харуулж байна. Мөн соёл урлаг чөлөөт цаг, эрх чөлөө ардчилал, хүрээлэн буй орчин гэсэн үзүүлэлтүүд өндөр байгаа нь харагдаж байна. Харин эдийн засаг, дэд бүтэц, эрүүл мэндийн хувьд дундаж хэмжээтэй байна. Хамгийн бага оноог цаг агаар авсан байна. Эрс тэс уур амьсгалтай, өвөлдөө -40°C хүртэл хүйтэрч, зундаа +40°C хүртэл халдаг нь цаг агаар гэсэн үзүүлэлт доогуур гарахад нөлөөлсөн байна.

Зураг 2. Амьдралын чанарын индексийн бүрэлдэхүүн үзүүлэлтүүд 2005-2008



Монгол улсын амьдралын чанарын индекс болон түүний бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийг бусад улс орнуудынхтай харьцуулж үзье. Дэлхийн ялгаатай хөгжлийн түвшин бүхий 198 орны 2008 оны амьдралын чанарын индексийг Зураг 3-д харууллаа. Монгол улс энэ жагсаалтын 100-р байранд буюу дунд хэсэгт байна. 2007 онд 108-р байранд, 2006 онд 114-р байранд орж байжээ. Эдгээрээс харахад манай орны амьдралын чанар бусад улс оронтой харьцуулахад өсөх хандлагатай байна.


Зураг 3. Улс орнуудын амьдралын чанар



Эх үүсвэр: <http://www.internationalliving.com>

Шилжилтийн эдийн засагтай орнуудын амьдралын чанарыг Зураг 4-г харууллаа. Монгол улсын хувьд 26 орноос 55 гэсэн оноотойгоор 19-р байранд байна. Үүнээс харахад манай улс шилжилтийн орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байна.

Зураг 4. Шилжилтийн эдийн засагтай орнуудын амьдралын чанар



Эх үүсвэр: "2008 quality of life index" report

Бүлэг 3. Шилжилтийн эдийн засагтай орнуудын амьдралын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ

3.1. Тоон өгөгдөл ба загварчлал

а. Шилжилтийн эдийн засагтай орнуудын амьдралын чанарт нолоолох хүчин зүйлсийн шинжилгээ

Энэ хэсэгт шилжилтийн эдийн засагтай 26 орны тоо мэдээллийг цуглуулж, 2006-аас 2009 оныг хүртэлх panel өгөгдлийг боловсруулж Panel Least Squares аргыг ашиглан эконометрик үнэлгээ хийсэн. Шилжилтийн орнуудыг Фишерийн 1996 оны “шилжилтийн эдийн засгийн өсөлт болон тогтворжилт” ажлаас авсан.

$$QLI = b_0 + b_1 * POP + b_2 * INF + b_3 * PERGDP + b_4 * UNEM + b_5 * ECONFRE + e \quad (1)$$

- QLI – Амьдралын чанарын индекс
- POP – хүн амын өсөлт
- INF – инфляцийн түвшин
- PERGDP – нэг хүнд ногдох ДНБ (мянган доллароор)
- UNEM – ажилгүйдлийн түвшин
- ECONFRE – эдийн засгийн эрх чөлөө (мянган доллараар)
- $b_1 - b_5$ – үнэлэгдсэн параметрууд, e - алдаа

Хүснэгт 4-т үнэлгээний анхны үр дүн болон сайжруулсан үр дүнг харууллаа.

Хүснэгт 2. (1) тэгшитгэлийн үнэлгээний үр дүн

Үнэлгээний анхны үр дүн				Үнэлгээг сайжруулсан үр дүн			
Үзүүлэлтүүд	Үнэлэгдсэн утга	T-stat	Prob	Үзүүлэлтүүд	Үнэлэгдсэн утга	T-stat	Prob
Тогтмол	50,9	9,43	0.0000	Тогтмол	47,07	10,9	0.0000
Хүн амын өсөлт	-3,18	-3.84	0.0002	Хүн амын өсөлт	-2.62	-4.72	0.0000
Инфляци	-0.44	-2.96	0.0038	Инфляци	-0.44	-3.81	0.0002
Нэг хүнд ногдох ДНБ	0.55	5.37	0.0000	Нэг хүнд ногдох ДНБ	0.58	8.89	0.0000
Ажилгүйдэл	-0.062	-1.37	0.1719	Ажилгүйдэл	-0.062	-2.4	0.0181
Эдийн засгийн эрх чөлөө	0.14	1,77	0.0782	Эдийн засгийн эрх чөлөө	0.19	3,19	0.0019
R squared	0.66	-	-	R squared	0.86	-	-
DW	1.08	-	-	DW	1.509	-	-
Ажиглалтын утга	130	-	-	Ажиглалтын утга	130	-	-
Улсуудын тоо	26	-	-	Улсуудын тоо	26	-	-

Эх үүсвэр: (1) тэгшитгэлийн Eviews.5 программын үнэлгээ

Уг үнэлгээ статистикийн хувьд сайн гарсан.

б. Эдийн засгийн эрх чөлөөний бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн амьдралын чанарт үзүүлэх нөлөө

Эдийн засгийн эрх чөлөө нь амьдралын чанарт эерэгээр нолоолж байгаа нь (1) тэгшитгэлийн үр дүнгээс харагдаж байна. Иймээс эдийн засгийн эрх чөлөөний индексийн тооцооллын бүрэлдэхүүнд багтдаг үзүүлэлтүүдээс амьдралын чанарт нолоолж байгаа үзүүлэлтүүдээр дахин панел өгөгдөл боловсруулж авч үзье.

$$QLI = b_0 + b_1 * busfre + b_2 * finfre + b_3 * freecorr + b_4 * govsize + b_5 * trafre + e \quad (2)$$

- Busfre – Бизнесийн эдийн засгийн эрх чөлөө
- Finfre – Санхүүгийн эдийн засгийн эрх чөлөө
- Freecorr – Авилгалын хэмжээ
- Govsize – төрийн хэмжээ
- Trafre – Худалдааны эдийн засгийн эрх чөлөө
- $b_1 - b_5$ – үнэлэгдсэн параметрууд, e - алдаа

Хүснэгт 3. (2) тэгшитгэлийн үнэлгээний үр дүн

Үнэлгээний анхны үр дүн (Хавсралт 4)				Үнэлгээг сайжруулсан үр дүн (Хавсралт 5)			
Үзүүлэлтүүд	Үнэлэгдсэн утга	T-stat	Prob	Үзүүлэлтүүд	Үнэлэгдсэн утга	T-stat	Prob
Тогтмол	40.19	7.07	0.0000	Тогтмол	37.8	7.58	0.0000
Бизнесийн эрх чөлөө	0.10	1.84	0.0686	Бизнесийн эрх чөлөө	0.13	3.41	0.0006
Санхүүгийн эрх чөлөө	0.10	3.22	0.0017	Санхүүгийн эрх чөлөө	0.08	3.83	0.0002
Авлигын хэмжээ	0.12	1.61	0.1104	Авлигын хэмжээ	0.13	2.35	0.0205
Төрийн хэмжээ	-0.14	-4.1	0.0001	Төрийн хэмжээ	-0.14	-4.62	0.0000
Худалдааны эрх чөлөө	0.16	2.33	0.0218	Худалдааны эрх чөлөө	0.17	2.91	0.0045
R squared	0.63	-	-	R squared	0.819	-	-
DW	1.18	-	-	DW	1.51	-	-
Ажиглалтын утга	104	-	-	Ажиглалтын утга	104	-	-
Улсуудын тоо	26	-	-	Улсуудын тоо	26	-	-

Эх үүсвэр: (2) тэгшитгэлийн Eviews.5 программын үнэлгээ
Уг үнэлгээ статистикийн хувьд сайн гарсан.

3.2 Үнэлгээний үр дүн

Дээрх үнэлгээнүүдээс гарсан үр дүнг нэгтгэж хүснэгт 6-д харуулья.

Хүснэгт 4. Амьдралын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөө

Хувьсагчид	Амьдралын чанарт үзүүлэх нөлөө	Үнэлэгдсэн утга
Хүн амын өсөлт	-	(-2.62)
Инфляци	-	(-0.44)
Нэг хүнд ногдох ДНБ	+	(0.59)
Ажилгүйдэл	-	(-0.06)
Эдийн засгийн эрх чөлөө	+	(0.2)
Бизнесийн эрх чөлөө	+	(0.14)
Санхүүгийн эрх чөлөө	+	(0.08)
Авлигын хэмжээ	-	(0.13)
Төрийн хэмжээ	-	(-0.14)
Худалдааны эрх чөлөө	+	(0.17)
Хүний хөгжил	+	(0.76)

Эх үүсвэр: (1, 2, 3) тэгшитгэлийн Eviews.5 программын үнэлгээ

Үнэлгээний үр дүнгээс харахад шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд хүн амын өсөлт, инфляцийн түвшин болон ажилгүйдэл нь амьдралын чанарт сөргөөр нөлөөлж, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн болон эдийн засгийн эрх чөлөө нь эергээр нөлөөлж байна. Эдгээр нь онолын таамаглалуудтай тохирч байгаа юм.

Мөн бизнес, санхүү, худалдааны эрх чөлөө нь амьдралын чанарт эергээр нөлөөлж харин төрийн хэмжээ болон авлигын түвшин нь сөргөөр нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд бизнес, худалдаа хийх нөхцөл бодолцоог сайн бүрдүүлж өгснөөр амьдралын чанарыг сайжруулж болно гэж үзэж болно. Мөн тухайн шилжилтийн эдийн засагтай орны банкны салбарын хөгжил болон санхүүгийн чөлөөт байдал нь амьдралын чанарт эергээр нөлөөлж байна. Харин засгийн газрын зардлын ДНБ-д эзлэх хэмжээ их байх нь амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байгаа учир энэ зардлыг бууруулах замаар амьдралын чанараа сайжруулж болно. Мөн тухайн улс авлигатай үр дүнтэй тэмцэж чадвал амьдралын чанар нь дээшлэх боломжтой гэдэг нь дээрх үр дүнгээс харагдлаа.

Үнэлгээний үр дүнгээс харахад хүний хөгжил нь амьдралын чанарт маш ихээр нөлөөлж байна. Энэ нь хүний хөгжлийн индексийн тооцоололд ашиглагддаг хэмжигдэхүүнүүд нь бүгд амьдралын чанарын индексийн тооцоололд ашиглагддагтай холбоотой. Хүний хөгжлийн индекс нь 1 функтээр дээшлэхэд амьдралын чанарын индекс 0.76 функтээр дээшилнэ гэсэн үр дүн гарсан.

Дүгнэлт

Энэхүү судалгааны ажилдаа амьдралын чанар хэмээх ойлголтыг судалж, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээг хийсэн. Амьдралын чанар нь нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны нөхцөл байдал зэрэг хүний хөгжил болон нийгмийн хөгжлийн асуудлуудыг тодорхойлогч үзүүлэлт юм. Иймээс улс орны нийгэм, эдийн засгийн дундаж үзүүлэлтүүдээс илүүтэйгээр амьдралын чанар нь тухайн улсын нийгмийн хөгжлийн түвшинг илэрхийлж харуулдаг. Манай улсын амьдралын чанар нь дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад дундаж түвшинд байгаа бөгөөд өнөөг хүртэл энэ талын судалгаа шинжилгээний ажил харьцангуй орхигдсон байна.

Судалгааны үр дүнд амьдралын чанарт хүний хөгжил, нэг хүнд ногдох ДНБ, эдийн засгийн эрх чөлөө нь эергээр нөлөөлж, ажилгүйдэл, хүн амын өсөлт, инфляци нь сөргөөр нөлөөлж байгаа нь харагдсан. Мөн эдийн засгийн эрх чөлөөний индексийн тооцооллын бүрэлдэхүүнд багтдаг үзүүлэлтүүдээс амьдралын чанарт нөлөөлж байгаа үзүүлэлтүүдээр дахин панел өгөгдөл боловсруулж амьдралын чанарт чухам аль хувьсагч хэрхэн нөлөөлж байгаа нь авч үзсэн. Уг үнэлгээний үр дүнд бизнесийн эрх чөлөө, санхүүгийн эрх чөлөө, худалдааны эрх чөлөө нь эергээр, авлигын хэмжээ болон төрийн хэмжээ нь сөргөөр нөлөөлж байгаа харагдлаа.

Дээрх үр дүн нь онолын үндэслэл болон таамаглалуудтай тохирч байгаа бөгөөд эконометрик үнэлгээнүүд нь статистикийн хувьд ач холбогдол сайтай гарсан. Цаашид энэ судалгааны хүрээг тэлж, олон хувьсагчийг шинээр авч үзэх бүрэн боломжтой.

Мөн Монгол улсын амьдралын чанарын өнөөгийн байдлыг судлан ололттой болон дутагдалтай талуудыг авч үзсэн. Шилжилтийн эдийн засагтай орнууд, тэр дундаа манай улсын хувьд амьдралын чанарын асуудалдаа анхаарал хандуулан түүнийг сайжруулах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь судалгааны үр дүнгээс ажиглагдлаа.

Ашигласан ном зүй

- Нээлттэй нийгэм форум, МУИС-ЭЗС, 2006, “Монгол улсын эрх чөлөөний тойм-2006 : Институцийн хөгжил-эдийн засгийн өсөлтийг түргэтгэх дараагийн үе шат”, ADMON ХК, Улаанбаатар хот
- МУИС, ЭЗС, 2007, “Төв азийн шилжилтийн эдийн засагтай орнуудад тулгарч буй асуудлууд”, МУИС-н хэвлэх үйлдвэр, Улаанбаатар хот
- Нээлттэй нийгэм форум, МУИС-ЭЗС, 2008, “Монгол улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм-2008 : Монголын эдийн засаг дахь төрийн оролцоо”, Улаанбаатар хот

- Soren Ventegodt, Joav Merrick, Niels Jorgen Andersen, 2003, "Quality of life theory" ScientificWorld Journal, pp 1030-1040. Available at: http://www.amscoPub.com/images/file/File_97.pdf
- Robert J.Barro, Xavier Sala-i-Martin, 1999, Economic Growth, MIT Press, New York
- Fischer.S, Sahay.R, Vegh.C.A, 1996, 'Stabilization and growth in transition economies: The early experience', Journal of Economic perspective, Vol.10, No.2
- Richard A.Easterlin, Laura Angelescu, April 2007, Modern economic growth and quality of life: Cross sectional and Time series evidence. Available at: (<http://ftp.iza.org/dp2755.pdf>)
- Stephanie Seguino, 2002, 'Gender, quality of life, and growth in asia 1970 to 1990' Available at: <http://www.uvm.edu/~econ/Gender%20and%20Quality%20of%20Life%2010-02.pdf>
- Heritage Foundation 2008, 'Index of economic freedom', Available at : <http://www.heritage.org/index>
- Malcolm Shookner, 1997, 'The quality of life Ontario 1997'
- Erin Hoffman, 2007, 'What is quality of life ?'
- Anna Donald, 2001, 'What is quality of life ?' Hayward group pls, Vol. 1, number 9, www.evidence-based-medicine.co.uk
- E.Diener, D.R.Rahtz, 2004, 'Advances in quality of life theory and research', Kluwer Academic Publishers. pp-266
- Rebecca Renwick, Ted Mverscough, 'Quality of life' www.quality.oflife@utoronto.co
- Jordan Matthew Prutkin, 2002, 'A history of quality of life measurements'
- Carlens.E, Daslstrom.G, Nou.E, 1970 , 'Comparative measurements of quality of survival of lung cancer patients after diagnosis', Scand J Resp, Dis 51:268-275
- Tofler.A, 1970, 'Life units', Br Heart J, 32:771-773
- Priestman.T, Baum.M, 1976, 'Evaluation of quality of life in patients receiving treatment for advanced breast cancer', Lanset. 1(7965):899-901
- Simmons.R, Anderson.C, Kamstra.L, 1984, 'Comparison of quality of life of patients on continuous ambulatory peritoneal dialysis, hemodialysis, and after transplantation', Am J Kid Dis. 4:253-255